

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ, ДАРАМТААС АНГИД БАЙХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь ялгаварлан гадуурхалт, дарамтыг илрүүлэх, таслан зогсоох, үр дүнтэй хамгаалах, урьдчилан сэргийлэх тогтолцооны эрх зүйн үндсийг тогтооход оршино.

2 дугаар зүйл. Ялгаварлан гадуурхалт, дарамттай тэмцэх хууль тогтоомж

2.1.Ялгаварлан гадуурхалттай тэмцэх хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлын тухай, Хөдөлмөрийн тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Ахмад настны тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжоос бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

2.3.Монгол Улсын хууль тогтоомжид ялгаварлан гадуурхалт, дарамтаас сэргийлэх, түүнтэй тэмцэх талаар тусгайлан заасан бол энэ хууль тогтоомжид хамаарна.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Монгол Улсын иргэн, Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга болон түр оршин сууж байгаа гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн энэ хуулийн үйлчлэлд хамаарна.

4 дүгээр зүйл.Ялгаварлан гадуурхлаас ангид байх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зарчим

4.1.Ялгаварлан гадуурхалт, дарамтаас ангид байх үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хуульд заасан зарчмаас гадна дараахь зарчмыг баримтална:

4.1.1.хүний нэр төрийг хүндэтгэх, үл буруутгах, аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байх;

4.1.2.хүний нэр төр, алдар хүнд, хувийн мэдээллийг хамгаалах;

4.1.4.ялгаварлан гадуурхалт, дарамтыг үл тэвчих.

5 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

5.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

5.1.1."ялгаварлан гадуурхалт" гэж хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, эрүүл мэндийн нөхцөл байдлаар ялгаварлан гадуурхах сэдлээ үг хэлээр, биеэр, өөр хэлбэрээр илэрхийлж тэвчишгүй орчин үүсгэх үйлдэл, эс үйлдэхүйг;

5.1.2."ажлын байрны дарамт" гэж ажил, албан тушаалын байдлаар хүнийг үг хэл, бие, бусад хэлбэрээр доромжилж, айлган сүрдүүлж тулган шаардаж ажил албан тушаал, эд материал, сэтгэл санаа бусад байдлаар хохирох үр дагавар бүхий тэвчишгүй орчин үүсгэх үйлдэл, эс үйлдэхүйг;

5.1.3."бэлгийн дарамт" гэж бусдад ажил, албан тушаал, нэр төр, алдар хүнд, эд хөрөнгө, сэтгэл санааны үр дагавар үүсгэж бэлгийн харьцааны шинжтэй үйлдэл хийх сэдлээ үг хэлээр, биеэр, өөр хэлбэрээр илэрхийлэх бусад байдлаар хохирох үр дагавар бүхий тэвчишгүй орчин үүсгэх үйлдэл, эс үйлдэхүйг;

5.1.4. "ёс зүйн дарамт" гэж Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан, нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн үнэт зүйл, хүний эрхийн зарчим, хэм хэмжээнд нийцэхгүй илт хууль бус аливаа үйлдэл, эс үйлдэхүйг мэдсэн боловч түүнийг тэвчин өнгөрөхөөс аргагүй нөхцөлд оруулахыг;

5.1.5."бэлгийн шинжтэй халдлага" гэж хүний биеийн эмзэг хэсэгт санаатайгаар хүрэх, биеийн эмзэг хэсэгт чиглэсэн дүрсний, дуу дүрсний бичлэг хийх, бэлгийн шинжтэй үйлдэл, үг хэлээр халдахыг;

5.1.5. "ялгаварлан гадуурхалт, дарамтын хохирогч" гэж энэ зүйлд заасан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас сэтгэл санаа, эдийн засаг, бие махбод, нэр төрийн болон бэлгийн халдашгүй байдлаараа хохирсон хүнийг;

5.1.6."мэдээлэгч" гэж энэ хуульд заасан ялгаварлан гадуурхалт, дарамтын талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдээлэл өгсөн хүнийг.

5.1.7."хүчирхийлэл үйлдэгч" гэж энэ зүйлд заасан ялгаварлан гадуурхсан, дарамт учруулах үйлдэл, эс үйлдэхүй гаргасан хүн, хуулийн этгээдийг.

6 дугаар зүйл. Ялгаварлан гадуурхалт, дарамтын хэлбэр

6.1.Энэ хуульд заасан дараахь үйлдэл, эс үйлдэхүйг ялгаварлан гадуурхалтын хэлбэр гэж үзнэ:

6.1.1.шууд ялгаварлан гадуурхалт;

6.1.2.шууд бус ялгаварлан гадуурхалт;

6.1.3.ажлын байрны дарамт;

6.1.4.бэлгийн дарамт;

6.1.5.ёс зүйн дарамт;

6.1.6.бэлгийн шинжтэй халдлага.

6.2.Хууль ёсны дагуу, бодит үндэслэлтэй, тухайн зорилгод хүрэхэд тохиромжтой, шаардлагатай арга хэрэгслээр хэрэгжүүлэх боломжтой, хүлээн зөвшөөрөгдөхүйц байхаас бусад тохиолдолд энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-д заасан үйлдэл, эс үйлдэхүйгээр нэг хүн, эсхүл бүлэг этгээдийг өөр хүн, хэсэг бүлэг этгээдтэй ижил буюу ижил нөхцөл байдалд оруулсан эсхүл тэгш бус байдалд оруулсныг шууд ялгаварлан гадуурхалт гэнэ.

6.3.Хуульд заасан үндэслэл, журмын дагуу тогтоосон заалт, шалгуур нь хууль ёсны, бодит үндэслэлтэй, тухайн зорилгод хүрэхэд тохиромжтой, шаардлагатай арга хэрэгслээр зохицуулахаас үндэслэлээр энэ хуулийн 5.1 дахь хэсэгт заасан үйлдэл, үйлдэл, эс үйлдэхүйгээр аливаа хүн, бүлэг этгээдийг бусад хүн, бүлэг хүмүүсийн хувьд тэгш бус байдалд хүргэж болзошгүй нөхцөл байдалд хүргэсэн эсхүл тийм нөхцөл байдлыг үүсгэсэн зохицуулалт, журам, шалгуур тогтоохыг шууд бус ялгаварлан гадуурхалт гэнэ. Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтад заасан зорилго, сэдлээр тодорхой хүн, бүлэг хүмүүсийг ялгаварлан гадуурхахыг өдөөн турхирсан, зааварласныг шууд бус ялгаварлан гадуурхалтад хамааруулна.

6.4.Хуульд заасны дагуу ажлын байрны зохицуулалт хийх, ажлын чиг үүрэг, ажлын байрыг өөрчлөх, сэлгэн ажиллахыг санал болгосон, төрийн албаны болон хөдөлмөрийн харилцааг дуусгавар, ажлаас халах болгох илэрхийлэх, мэдэгдэх, сонсох ажиллагаа хийх, ёс зүйн болон сахилгын шийтгэл оногдуулах тухай илэрхийлсэн нь хууль ёсны дагуу бодит үндэслэлтэй, хүлээн зөвшөөрөгдөхүйц байхаас бусад тохиолдолд энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтад заасан 5.1.1 дахь заалтад заасан үйлдэл, үйлдэл, эс үйлдэхүйгээр нэг хүн, эсхүл бүлэг этгээдэд тэвчишгүй орчин үүсгэхийг хэлнэ.

6.5.Нийгэмд тогтсон харилцааны ёс зүй, уламжлалыг дагахаас бусад зорилгоор, харилцааны тогтсон хэм хэмжээнээс хэтэрсэн тодорхой хүн, бүлэг хүн рүү чиглэсэн энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д заасан үйлдэл эс үйлдэхүйг бэлгийн дарамт гэнэ. Бэлгийн дарамтын шинжтэй аливаа үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг, зөрчилд тооцсон нь энэ хуульд заасан хамгаалалтыг хэрэгжүүлэх, хууль бус үйлдэл, эс үйлдэхүй хийсэн аливаа этгээдийг энэ хуульд заасан хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

6.6.Илт хууль бус үйлдэл, эс үйлдэхүйд оролцохыг шаардах, тухайн хууль бус үйлдэлийг мэдсээр байж дуугүй байхыг тулгах, хүний эрхийн зөрчил болон гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй хууль бус үйлдлийг мэдэгдэх, мэдээлэх боломжгүй болгох нөхцөл байдалд оруулсан энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т заасан үйлдэл, эс үйлдэхүйг ажлын байрны дарамт гэнэ. Хууль тогтоомжоор хүлээсэн, мэргэжлийн онцлог, мэргэжлийн болон ёс зүйн дүрмийг хэрэгжүүлснийг ёс зүйн дарамтад хамааруулахгүй.

6.7.Гэмт хэргийн шинжгүй боловч хохирогчийн биеийн эмзэг хэсэгт, зөвшөөрөлгүйгээр санаатайгаар бэлгийн сэдлээр хүрэх эсхүл уг сэдлээр гэрэл зураг авах, дуу дүрсний бичлэг хийх зэргээр хохирогчид халдсан үйлдлийг бэлгийн шинжтэй халдлага гэнэ.

6.8.Энэ хуулиас гадна бусад хууль тогтоомжид жендэрийн, хүүхдийн, хөгжлийн бэрхшээлтэй хүний, ахмад настны эрхийг хамгаалах, ялгаварлан гадуурхалт, дарамтаас урьдчилан сэргийлэх талаар тусгайлан заасан бол тухайн хуульд заасны дагуу арга хэмжээ авч, хуулийн хэрэгжилтийг хангуулна.

7 дугаар зүйл. Ялгаварлан гадуурхалт, дарамтын талаар гомдол, мэдээлэл гаргах

7.1.Ялгаварлан гадуурхалт, дарамттай холбоотой гомдол, мэдээллийг хохирогч өөрөө, эсхүл бусдаар дамжуулан гаргана.

7.2.Гомдол, мэдээллийг хүлээн авсан, хянан шийдвэрлэж байгаа албан тушаалтан хохирогчийн хувийн мэдээллийг нууцлах, задруулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

7.3.Ялгаварлан гадуурхалт, дарамтад өртсөн гэж хүн эсхүл тодорхой бүлэг хүн үзвэл энэ тухай гомдол, мэдээллийг биечлэн, эсхүл хууль ёсны төлөөлөгч болон бусдаар дамжуулан гаргах нөхцөлийг хангах ба шаардлагатай бол хууль тогтоомжид заасны дагуу туслалцаа үзүүлж, хамгаална.

7.4.Ялгаварлан гадуурхсан, дарамтыг дэмжсэн шинжтэй эсхүл хохирогчтой холбоотой мэдээ, мэдээлэл, зар сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон бусад хэлбэрээр түгээхийг хориглоно.

7.5.Нийгэмд нийтийн мэдээллийн хэрэгслээр илэрхий болсон, илт тодорхой баримтын хүрээнд тодорхой хүний болон тодорхой бүлгийн ялгаварлан гадуурхалт, дарамт байгаа эсэхийг гомдол, мэдээлэл гаргасан эсэхээс үл хамааран энэ хуульд заасан эрх бүхий албан тушаалтан, байгууллага хянан шалгана.

7.6.Хохирогч нь төрийн албан тушаалтан, ажилтан бол энэ хуулийн 11, 12, 13, 14, 15, 16, 17 дугаар зүйлд заасан субъектэд ялгаварлан гадуурхсан, дарамталсан талаар гомдол, мэдээллийг гаргана.

7.7.Ялгаварлан гадуурхсан, дарамталсан албан тушаалтан нь шууд удирдах болон дээд шатны албан тушаалтан нь хохирогчид нөлөөлж, хууль ёсны эрх ашиг сонирхол хохирол, хор уршиг учруулж болзошгүй, гомдол мэдээллийг төрийн албаны салбар зөвлөл шийдвэрлэхэд хууль бусаар нөлөөлж болзошгүй үндэслэлтэй эсхүл хуулийн этгээдийн албан тушаалтан бол Хүний эрх хамгаалагчийн хороонд гомдол, мэдээллийг гаргана.

8 дугаар зүйл. Хохирогчийн эрхийг хангах, хамгаалах

8.1.Хохирогчийн эрхийг Төрийн албаны ёс зүйн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлын тухай хуульд зааснаас гадна дараахь байдлаар хангана:

8.1.1.энэ хуульд бусад хууль тогтоомжид заасан тусламж үйлчилгээ, хамгаалалт үзүүлэх;

8.1.2.хууль зүйн туслалцаа үзүүлэх эрх бүхий этгээд, өмгөөлөгч, төрийн, төрийн бус байгууллага хохирогчийн эрх ашгийг хуульд заасны дагуу төлөөлөх;

8.1.3.гомдол мэдээллийг хянан шийдвэрлэх ажиллагааны явц, нөхцөл байдал болон хүлээлгэсэн хариуцлагын талаархи мэдээллийг танилцуулж, тайлбарлан өгөх;

8.1.4.хуульд заасан бусад.

8.2.Хохирогч түүнийг төлөөлөн гомдол, мэдээлэл гаргасан хүнд хохирол учруулах, хохирол учруулж болзошгүй дараах үйлдлийг хориглоно:

8.2.1.гомдол, мэдээлэл гаргасантай холбогдуулан албан тушаал бууруулах, албан тушаал дэвшүүлэхийг хязгаарлах, сахилгын шийтгэл оногдуулах, ажлаас халах, ажлаас чөлөөлөхийг шаардах;

8.2.2.өөрийн зөвшөөрөлгүй албан үүргийн хуваарилалтыг өөрчлөх, шилжүүлэх;

8.2.3.цалин хөлсийг үндэслэлгүйгээр бууруулах, ажлын байр, аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой хохирол учруулах, хохирол учруулж болзошгүй бусад үйлдэл, эс үйлдэхүй.

8.3.Хохирогч, мэдээлэгч энэ хуулийн 8.2-д заасан нөхцөл бүрдсэн гэж үзвэл эрх бүхий байгууллагад гомдол гаргаж болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ, ДАРАМТААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ШИЙДВЭРЛЭХ ТОГТОЛЦОО

9 дүгээр зүйл.Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын бүрэн эрх

9.1.Монгол Улсын Их Хурал ялгаварлан гадуурхалт, дарамтаас ангид байх, урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

9.2.Монгол Улсын Засгийн газар ялгаварлан гадуурхалт, дарамттай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

11 дүгээр зүйл.Төрийн захиргааны төв байгууллага, Ёс зүйн хороо, ёс зүйн дэд хорооны чиг үүрэг

11.1.Төрийн захиргааны төв байгууллага нь салбарын хэмжээнд ялгаварлан гадуурхалт, дарамтаас ангид байх, урьдчилан сэргийлэх ажлыг энэ хуульд заасны дагуу зохион байгуулах бөгөөд харьяа агентлаг, байгууллагын албан тушаалын тодорхойлолтод энэ хуульд заасан чиг үүргийг тусгасан байдалд хяналт тавина.

11.2. Ёс зүйн хороо, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь энэ хууль болон Төрийн албан хаагчийн ялгаварлан гадуурхсан, дарамт учруулсантай холбоотой гомдол, мэдээллийг хуульд заасны дагуу хүлээн авч шийдвэрлэнэ.

12 дугаар зүйл.Хүний эрх хамгаалагчийн хорооны чиг үүрэг

12.1.Хүний эрх хамгаалагчийн хороо нь Хүний эрх хамгаалагчийн тухай хуульд заасны дагуу ялгаварлан гадуурхалт, дарамтын улмаас хүний эрх эрх зөрчигдсөн талаарх гомдол, мэдээлэл гаргасан хүний эрх хамгаалагчийг хамгаалах, холбогдох эрх бүхий байгууллагад тухайн асуудлыг шийдвэрлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

13 дугаар зүйл.Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын чиг үүрэг

13.1.Энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтны ялгаварлан гадуурхалт, дарамтын улмаас хүний эрх эрх зөрчигдсөн талаарх гомдол, мэдээллийг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлээгүй, ёс зүйн зөвлөл, ёс зүйн дэд хороог байгуулаагүй, тухайн хороо, зөвлөл нь ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзвэл Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар хуульд заасны дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

14 дүгээр зүйл.Хүний эрхийн комиссын чиг үүрэг

14.1.Хүний эрхийн үндэсний комисс нь Хүний эрхийн комиссын тухай хуульд зааснаас гадна энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан төрийн албаны үйл ажиллагаанд хамаарахгүй хуулийн этгээд, аж ахуйн нэгж байгууллагад ялгаварлан гадуурхалт, дарамтын улмаас хүний эрх зөрчигдсөн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авч шийдвэрлэнэ.

17 дугаар зүйл.Прокурорын байгууллагын чиг үүрэг

17.1.Прокурорын байгууллага ялгаварлан гадуурхалт, дарамтын улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн тохиолдол бүрийг нарийвчлан судалж дүгнэлт гаргах, үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдэгдэл хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавина.

18 дугаар зүйл.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг Зохицуулах зөвлөл, Жендэрийн үндэсний хорооны чиг үүрэг

18.1.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг Зохицуулах зөвлөл, Жендэрийн үндэсний хороо хамтран ялгаварлан гадуурхалт, дарамтаас ангид байх, урьдчилан сэргийлэх ажлыг улсын хэмжээнд хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулна.

19 дүгээр зүйл.Төрийн бус байгууллагын чиг үүрэг

19.1.Төрийн бус байгууллага нь хохирогчийн хүсэлтээр түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагааг итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан хэрэгжүүлнэ.

19.2.Энэ хуулийн 19.1-т заасан итгэмжлэгдсэн төлөөлөгч дараахь эрх эдэлнэ:

19.1.1.хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр төрийн, төрийн бус байгууллага, бусад этгээдтэй харилцах;

19.1.2.ялгаварлан гадуурхалт, дарамттай холбоотой мэдээлэл олж авах;

19.5.3.ялгаварлан гадуурхалт, дарамтаас ангид байх, урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааны талаархи саналаа эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргах;

19.1.4.хохирогчийн хүсэлтээр зөрчил шалган шийдвэрлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох;

19.1.5.хохирогчийн нэр төр, амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор холбогдох байгууллага, хуулийн этгээд, бусад этгээдээс дэмжлэг хүсэх;

19.1.6.хуульд заасан бусад.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ, ДАРАМТЫГ ИЛРҮҮЛЭХ, ТАСЛАН ЗОГСООХ, ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

20 дугаар зүйл.Ялгаварлан гадуурхалт, дарамтыг илрүүлэх, мэдээлэх

20.1.Төрийн албан тушаалтан, ажил олгогч, ажилтан нь ялгарварлан гадуурхалт, дарамтын шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйн талаар энэ хуульд заасан эрх бүхий албан тушаалтан, байгууллагад мэдээлнэ.

20.2.Ялгаварлан гадуурхалт, дарамтын шинжтэй үйлдэл, эс үйлдэхийн талаар хохирогч, энэ талаар олж мэдсэн хүн холбогдох байгууллагад мэдээлэх эрхтэй.

20.3.Энэ зүйлийн 20.1, 20.2-т заасан мэдээлэл гаргагч нь хувийн мэдээллээ бусдад ил болгох зөвшөөрөл олгосон, эсхүл хуульд зааснаас бусад тохиолдолд мэдээлэгчийн талаарх мэдээллийг тодорхойлох боломжгүй болгож, нууцална.

20.4.Мэдээлэгчийн хувийн мэдээллийг энэ хуулийн 20.3-т зааснаас бусад үндэслэлээр задруулсан гэж үзвэл мэдээлэгч нь хуульд заасны дагуу гомдол гаргаж болно.

20.5.Хохирогч, мэдээлэгч нь өөрийгөө хамгаалуулахаар энэ хуулийн ... дугаар зүйлд заасан хамгаалалтын арга хэмжээ болон хуульд заасан шаардлагатай бусад арга хэмжээг авахыг Хүний эрхийн Үндэсний Комисс, хууль сахиулах байгууллагаас шаардаж болно.

20.6.Хохирогч, мэдээлэл гаргагч нь энэ хуулийн-д заасан хууль зүйн болон сэтгэл зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө авч болно.

20.7.Хохирогч, мэдээлэгч нь энэ хуульд заасан зөвлөгөө авах тухай хүсэлтийг эрх бүхий байгууллагад гаргах бөгөөд тухайн байгууллага хүсэлтийн дагуу шаардлагатай арга хэмжээ авна.

20.8.Хохирогч, хүний эрх хамгаалагч, мэдээлэгч нь эрх бүхий байгууллагад ялгаварлан гадуурхалт, дарамтын талаар мэдээлэл өгсөн асуудлаар олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагад хандаж болно. Олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллага нь тухайн асуудлыг мэдээлсэн эх сурвалжаа нууцлах эрхтэй.

21 дүгээр зүйл.Мэдээлэл солилцох, хамтран ажиллах

21.1.Ялгаварлан гадуурхалт, дарамтын талаар гомдол, мэдээлэл хүлээн авах, шийдвэрлэхээр энэ хуулийн Хоёрдугаар бүлэгт заасан байгууллага нь цахимаар болон бусад хэлбэрээр гомдол, мэдээлэл гаргах боломжийг бүрдүүлж, хоорондын үйл ажиллагааг уялдуулж, харилцан мэдээлэл солилцох үүргийг хүлээнэ.

21.2.Ялгаварлан гадуурхалт, дарамтаас ангид байх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбоотой хийсэн судалгаа, дүн шинжилгээ, үнэлгээний тайлан, илтгэлийн хүрээнд эрх бүхий байгууллагаас гаргасан зөвлөмж, шаардлагыг төрийн байгууллага, албан тушаалтан биелэлтийг хангуулж, арга хэмжээ авч ажиллана.

22 дугаар зүйл. Ялгаварлан гадуурхалт, дарамтыг таслан зогсоох

22.1.Энэ хуульд заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь хүчирхийлэл үйлдэгчээс хохирогчид хууль бусаар нөлөөлөхөөс сэргийлж хүчирхийлэгчийг тусгаарлах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

22.2.Эрх бүхий байгууллага нь ялгаварлан гадуурхалт, дарамтыг таслан зогсоох, хохирогчийг хамгаалахтай холбоотой дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

22.2.1.гомдол, мэдээллийн дагуу холбогдох байгууллагатай хамтран ажиллах;

22.2.2. хохирогч, мэдээлэгч эрхээ эдлэх нөхцөлийг бүрдүүлэх, хамгаалалтын арга хэмжээ зохион байгуулах;

22.2.3. хохирогчид хууль зүйн болон сэтгэл зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах;

22.2.4. хуульд заасан бусад.

23 дугаар зүйл. Хохирогчид үзүүлэх үйлчилгээний төрөл

23.1. Хохирогчид үзүүлэх үйлчилгээ дараахь төрөлтэй байна:

23.1.1. хамгаалалт;

23.1.2. сэтгэл зүйн зөвлөгөө;

23.1.3. хууль зүйн зөвлөгөө.

23.2. Энэ хуулийн 23.1-д заасан үйлчилгээг холбогдох байгууллага, албан тушаалтан хамтран үзүүлэх, үйлчилгээний талаархи мэдээллийг солилцох үүрэгтэй.

23.3. Хохирогчийн хүсэлтээр энэ хуульд зааснаас бусад төрлийн үйлчилгээ, түүнийг үзүүлдэг байгууллага, ажилтны талаархи мэдээллийг өгч болно.

23.4. Хохирогчид үйлчилгээ үзүүлэхэд бие эрүүл мэндийн болон жендэрийн хэрэгцээ, шаардлагыг харгалзана.

23.5. Энэ хуулийн 23.1-д заасан үйлчилгээг хохирогчид үнэ төлбөргүй үзүүлнэ.

23.6. Энэ хуульд заасан эрх бүхий байгууллага, цагдаагийн байгууллагын гэрч хохирогчид туслалцаа үзүүлэх алба нь үнэлгээ хийсний үндсэн дээр хохирогчийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

23.7. Хохирогчид сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлэх журмыг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

23.8. Хууль зүйн туслалцааны төв, Монголын Хуульчдын Холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоотой хамтран хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулна.

23.9. Хохирогчид өмгөөллийн үйлчилгээг хуульд заасан журмын дагуу үзүүлнэ.

23.10. Хохирогч өөрөө зөвшөөрч хүсэлт гаргаснаас бусад тохиолдолд хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулахыг хориглоно.

24 дүгээр зүйл. Хүчирхийлэл үйлдэгчид авах арга хэмжээ, хүлээлгэх хариуцлага

24.1. Эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь гомдол, мэдээллийг шалгах явцад хүчирхийлэл үйлдэгчид тусгаарлах дараах арга хэмжээг авна. Үүнд:

24.1.1. хохирогчтой ойртох, уулзах, хууль бусаар нөлөөлөхийг хориглож сануулах

24.1.2. ажлын байранд бусад хүмүүстэй уулзах нөлөөлөхийг хориглож сануулах,

24.2. Ялгаварлан гадуурхсан, дарамталсан үйлдэл эс үйдэхүй нь гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй бол цагдаагийн байгууллагад харьяаллын дагуу шилжүүлнэ.

24.3.Энэ хуульд заасны дагуу ялгаварлан гадуурхсан, дарамталсан, бэлгийн шинжтэй халдлага гарсныг тогтоосон бол хүчирхийлэл үйлдэгчид дараах хариуцлага хүлээлгэнэ.Үүнд:

24.3.1.Төрийн албаны тухай хууль болон бусад хуульд заасан үндэслэлээр ажлаас чөлөөлөх, халах, хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгох талаар томилсон эрх бүхий байгууллага албан тушаалтанд мэдэгдэх.

24.3.2.хохирогчоос уучлал гуйлгах

24.3.3.өөрт нь хаалттай сануулах

24.3.4. сануулж олон нийтэд нээлттэй мэдээлэх

24.3.5.сахилгын болон ёс зүйн, мэргэжлийн дүрэмд зааснаар хариуцлага хүлээлгэхээр томилсон буюу эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэх.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

25 дугаар зүйл. Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих

25.1.Ялгаварлан гадуурхалт, дарамтаас ангид байх, урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд дараахь хэлбэрээр хяналт тавина:

25.1.1.Монгол Улсын Их Хурал хууль тогтоомжийн биелэлтийн талаарх Засгийн газрын тайланг 2 жил тутам хэлэлцэн, шийдвэр гаргах;

25.1.2.Монгол Улсын Засгийн газар, Төрийн захиргааны төв байгууллага, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Жендерийн үндэсний хороо, Төрийн албаны Ёс зүйн хороо, дэд хороо, Прокурорын байгууллага, Хүний эрхийн үндэсний комисс энэ хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлж, биелэлтийг хангах;

25.1.3.ялгаварлан гадуурхалт, дарамтаас ангид байх, урьдчилан сэргийлэх чиг үүргийг хуулиар хүлээсэн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг уялдуулан, хамтын ажиллагааг зохицуулах;

26 дугаар зүйл.Санхүүжилт

26.1.Гэмт хэрэг, зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 10-аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг энэ хуульд заасны дагуу хохирогчид тусламж, үйлчилгээ үзүүлэх, хамгаалахад зориулан тухайн байгууллагын дараагийн жилийн төсөвт тусгаж, санхүүжүүлнэ.

27 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

27.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтанд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны ёс зүйн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

27.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

27.3.Энэ хуулийг зөрчсөн хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага хүлээлгэсэн нь тухайн зөрчлийг арилгах, зөрчлийн улмаас бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөх хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

28 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох хугацаа

28.1.Энэ хуулийг ... оны ... дугаар сарын ... -ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ